



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/282

Булган сум

Тусгай зөвшөөрлийн тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3 дугаар бүлгийн 3.2 дахь зүйлийн 1.1, 8 дугаар бүлгийн 8.1 дэх зүйлийн 12.13, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 40 дүгээр зүйлийн 40.7, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2.1, 35.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг сунгах цэгийн нэрсийг 1 дүгээр хавсралтаар баталж, “Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”-ийн 15.7-д заасны дагуу тусгай зөвшөөрлийн тоог батлах хүртэлх хугацаагаар сунгасугай.

2.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасны дагуу “Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл” сунгахад хураах тэмдэгтийн хураамжийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг сумын Засаг дарга нар, Татварын хэлтэс (Д.Лхагвасүрэн), Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Давааням)-т тус тус үүрэг болгосугай.

3.Дээрх цэгүүдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, журам, стандартуудын хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга, аймгийн Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Л.Ганбаатар), Татварын хэлтэс (Д.Лхагвасүрэн), аж ахуйн нэгж байгууллагын удирдлага; Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дүгээр сарын 20-ны өдрийн АРХАА дугаар
захирамжийн хавсралт



СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ ЦЭГИЙН НЭРС

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн овог, нэр	Үйлчилгээний терөл	Бар, ресторана, дэлгүүрийн нэр	Тохирлын үнэлгээний шаардлага хангасан эсэх
1	Баяннуур	"Салхин зээрд" ХХК	Д.Тайванжаргал	Хүнсний дэлгүүр	"Салхин зээрд"	Тийм
2	Бугат	"Маргад Орхон" ХХК	Д.Баярмаа	Хүнсний дэлгүүр	"Баян айраг"	Тийм
3		"Агуйт түрүү" ХХК	Гомбосүрэн Ганбат	Хүнсний дэлгүүр	"Агуйт"	Тийм
4		"Жаран морьт" ХХК	Г.Оюунмаа	Баар	"Жаран зоог"	Тийм
5	Булган	"Очир шонхор" ХХК	Б.Жаргалбат	"Шонхор маркет"	Хүнсний дэлгүүр	Тийм
6		"Очирхүү" ХХК	Д.Батсайхан	Хүнсний дэлгүүр	"Халиун"	Тийм
7		"Эрчит сүн" ХХК	Ж.Цогтбаатар	Хүнсний дэлгүүр	"Нандин"	Тийм
8	Гурванбулаг	"Үржил трейд" ХХК	Б.Эрдэнэтулга	Хүнсний дэлгүүр	"Гурванбулаг"	Тийм
9	Дашинчилэн	"Наху" ХХК	С.Нандинцэцэг	Хүнсний дэлгүүр	"Оргих"	Тийм
10		"Огуль хөгжил" ХХК	Н.Болд	Хүнсний дэлгүүр	"Огуль"	Тийм
11		"Чин хайрхан төв" ХХК	Б.Майцэцэг	Супермаркет	"Чин хайрхан"	Тохирлын гэрчилгээтэй
12		"Чин хайрхан төв" ХХК	Б.Майцэцэг	Зоогийн газар	"Чин хайрхан"	Тохирлын гэрчилгээтэй
13	Рашаант	"Натур тур" ХХК "Хөгнө хан" жуулчны бааз	Э.Туул	Амралтын газрын дэргэдэх баар	"Хөгнө хан"	Тохирлын гэрчилгээтэй
	Нийт- 13					